



ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 16

Тавин

Хоршоог хөгжүүлэх сангаас олгох
зээлийн дээд хэмжээг тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5. дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13- ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан " Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам" –ын 3.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хоршоог хөгжүүлэх сангаас олгох зээлийн дээд хэмжээг нэг төсөлд 45000000 төгрөг хүртэл тогтоосугай.
2. Зээл олгох үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулж, тайланг жил бүр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Ч.Уранчимэг)-т үүрэг болгосугай.
3. энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.ЭНХБАЯР